



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 19 өдөр

Дугаар А/648

Номгон

Улсын бүртгэлийн хэлтэст эрх шилжүүлэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2. а, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын бүртгэлийн хэлтсийн үйл ажиллагаанд ашиглах тоног төхөөрөмж авахад шаардагдах 5,000,000 (Таван сая) төгрөгийг тус хэлтэст эрх шилжүүлж, гүйцэтгүүлсүгэй.

2. Эрх шилжсэнтэй холбогдуулан худалдан авах ажиллагааг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн дагуу 10 дугаар сарын 25-ны дотор зохион байгуулж, явцын ажилд хяналт тавьж ажиллахыг Улсын бүртгэлийн хэлтэс (Ц.Мөнхжаргал)-т үүрэг болгосугай.

3. Дээрх 5,000,000 (Таван сая) төгрөгийг аймгийн хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс /С.Байгалмаа/-т зөвшөөрсүгэй.

4. Улсын бүртгэлийн хэлтсийн үйл ажиллагаанд ашиглах тоног төхөөрөмж авах ажилд хяналт тавьж ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтэс (Д.Сарангарав)-т даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

601210511